

хэзээ язаанаас монголчуудын түншлэхийг хүсдэг Европын их гүрэн мөн юм. Үүнийг олны дунд нэр хүнд бүхий “Сант Марал” сангийн санал асуулга байнга нотолдог боловч Монгол Улс чухамдаа Орос, Хятад хоёрын дунд биш, АНУ, Хятад хоёрын дунд байгаа нь Оросын өөрийнх нь эдийн засаг доройгоос болоод буйг Москва анзаарсан биз.

Жижигхэн Монголын ард түмэн өнөөдөр ч гэсэн өчигдрийнхөө нэгэн адил дэлхийн улс төрийн бодлогын тээрийн чулуудын дунд сууж байна. Гэвч улс төрчид нь тээрийн ийм чулуудын дундуур чамгүй амжилттайгаар бодлого явуулж сурчээ. Олон тулгуурт бодлого эерэг нөлөөгөө үзүүлж эхлээд байна. Дэлхийн томчууд Монгол хэмээх нэгэн нэрийг аль хэдийн мэддэг болжээ. Гэвч хөгжил дэвшилд хүрэхийн жинхэнэ баталгаа нь үндэсний эв нэгдэл, үндэсний онцлогоо хадгалах явдал мөн гэдгийг монголчууд өөрсдөө ухамсарладаг. Энэ ч утгаараа Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н. Багабанди “үндэсний үзэл бахархлыг өдөөж, үндэсний гэх аливаа бүхнийг шинэ цагийн шаардлага, дэлхийн соёлын хэмнэлд нийцүүлэн сэргээж, эвдэрснийг эвлүүлэн, тасарсныг залгуулж, даяаршлын эринд дангааршин орших үндэсний онцлогоо хамгаалан хөгжүүлэх бодлогыг эцгийн голомтыг бадраах хүүгийн сэтгэлээр, эртний түүхт төр улсын Ерөнхийлөгчийн бодлогоор явуулж ирлээ”³⁵ гээд үргэлжлүүлэхийг уриалж байсан билээ. 2005 оны арван нэгдүгээр сарын сүүлчээр Монголын хэвлэлд нийтлэгдсэн “Монгол Улсын иргэдэд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”³⁶ мөн үүнд чиглэгдэж байгаа болно.

Ерөнхийлөгч Н. Энхбаяр ч эдгээр зорилгыг өөрийн үүрэг гэж үзэж байгаа бөгөөд монголчууд энэ онд Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх тул тэрээр дэлхийн өнцөг булан бүрээс, түүний дотор мэдээж Герман орноос зочид гийчид, анд нөхдөө хүлээж авах нь лавтай. Монголын улс төрчид энэ завшааныг ашиглан герман түншүүдтэйгээ бас хоёр талын харилцаагаа цаашид хөгжүүлэх талаар ярилцах болно. Герман Улстай *иж бүрэн түншлэлийн* харилцаа тогтоохыг хүсдэг тухай Монголын сонин хэвлэлүүдэд олонтаа дурдсан байдаг юм билээ.

³⁵ Ард түмнийхээ, бас ардчилал, шудрага ёсны талд зогсохыг хичээж ирлээ, Өнөөдөр, 2005.06.23

³⁶ Монгол Улсын иргэдэд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр, Өнөөдөр, 2005.11.23

ТАЙВАНИЙ БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТЫН ҮЙЛ ЯВЦ БОЛОН ХЭТИЙН ТӨЛӨВ

Ху Жун Кунь*

Өмнөх үг

Ардчиллыг хөгжүүлэх үйл явц Тайваньд сүүлийн 10 жилд улам эрчтэй болж байна. 1996 онд явуулсан ерөнхийлөгчийн шууд сонгууль, 2000 онд эрх баригч нам солигдсон болон өнөөдөр /2004/ өрнөж байгаа бүх ард түмний санал хураалт явуулах хөдөлгөөн зэрэг нь Тайваньд ард түмний санал өгөх эрх хэрэгжиж байгаа болон ардчиллын үйл явц гүнзгийрч байгааг гэрчилж байна.

2004 оны гуравдугаар сарын 20-нд Тайваний түүхэнд анх удаа нийт ард түмний санал хураалт явагдсан нь тус улсын болон Тайваний хоолойн хоёр талын төлөөлөгчдийн хийгээд бүх дэлхийн олон нийтийн анхаарлыг ихэд татсан юм. Улсын дотоод хүрээнд санал хураалт явуулах нь ардчиллын бодлогын ирээдүйн хөгжилд нөлөөлөх эсэхэд анхаарал хандуулж байв. Тайванийн хоолойн хоёр талын харилцааны хүрээнд бол санал хураалт нь Тайваний тусгаар тогтнох алхам болж, ингэснээрээ дайнд хүргэх юм биш биз? гэдэгт анхаарал төвлөрч байв. Олон улсын хувьд бол санал хураалт явуулах нь Зүүн Азийн тогтвортой байдалд нөлөөлж, олон улсын хүчний хуваарилалт өөрчлөгдөх юм биш биз? гэсэн асуулт тулгарч байгаа юм.

Тайваний бүх ард түмний санал хураалтын эх сурвалж

1. Ерөнхийлөгч Чэнь Шуйбянийн санаачлага байв.

2003 оны есдүгээр сарын 23-нд Ардчилсан дэвшилтэт нам байгуулагдсаны 17 жилийн ойг тэмдэглэх үеэр ерөнхийлөгч Чэнь Шуйбянь Тайваний түүхэнд анхны бүх ард

* МУИС, ОУХС-ийн докторант

түмний санал хураалтыг энэ онд явуулахыг ил уриалсан юм¹. Энэ мөчөөс эхлэн Ардчилсан дэвшилтэт нам бүх ард түмний санал хураалт явуулах замын хөшгийг нээсэн байна. Хожим нь ерөнхийлөгч Чэнь Шуйбянь 2006 онд бүх ард түмний санал хураалт явуулах замаар шинэ хуулиудыг шинжлэн дүгнэх, 2008 оны тавдугаар сарын 20 гэхэд шинэ хуулиудын талаар явуулах «бүх ард түмний санал хураалтуудын хуанлийг» гаргахыг нэг бус удаа уриалж байсан ба уг санал хураалтыг явуулах асуудал нь ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан дэвшилтэт намын сурталчилгааны компанит ажлын гол хэсэг болсон байна.

2. Парламентад бүх ард түмний санал хураалтад зориулсан хууль тогтоомжийн бааз суурь тогтоох гэсэн Ардчилсан дэвшилтэт намын эрмэлзэл.

Бүх ард түмний санал хураалтын тухай хуультай болгоход тус дөхөм үзүүлэх гэсэн Ардчилсан дэвшилтэт намын оролдлогууд анхандаа бараг амжилт олоогүй юм. Парламентад сөрөг намуудын төлөөллийн олонхийн хязгаарлах нөлөө мэдрэгдэж байсан ба үүний үр дүнд Ардчилсан дэвшилтэт намаас оруулсан «Бүх ард түмний санал хураалтын тухай хууль» парламентад сорилт давж чадаагүй юм. Хууль тогтоох юанийн дарга Ю Си-кунь парламентад байх үедээ «Хуульчилсан зүйл гараагүй ч байлаа гэсэн зөвлөлдөх санал хураалтыг явуулж байх нь зүйтэй» гэж хашгирахад хүрч байжээ. Парламентад сөрөг «хөхийн» бүлэг давамгайлж байхад 2003 оны 11-р сарын 27-нд парламент «Бүх ард түмний санал хураалтын тухай хуулийг» гурав дахь хэлэлцүүлгээр баталсан байна. Ингэснээр Тайваньд бүх ард түмний санал хураалт явуулах нь хуулийн үндэстэй болов.

3. «Бүх ард түмний санал хураалтын тухай хуулийн» шинж чанар болон агуулга.

1/ «Бүх ард түмний санал хураалтын тухай хууль» нь идэвхгүй, аядуу заалтуудын төрөлд хамаарна. Ирээдүйд үндсэн хуулийн агуулгын өөрчлөлтүүдийг үндсэн хуулийн засалтын тогтсон үйл ажиллагааны дараа бүх ард түмний санал хураалтын явцад дахин тодорхойлохыг хуулийн зүйл тодорхойлсон байна. Өөр үгээр хэлбэл үндсэн хуулийн зохих зүйлийн агуулгын өөрчлөлтүүдийг Парламентын зүгээс идэвхгүй санал болгосны дараа л ард түмэн «бүх ард түмний санал хураалтын» явцад дахин тодорхойлж болох юм².

2/ «Үндсэн хуулийн байгууллагын талаарх бүх нийтийн санал хураалт», «төрийн далбаа, улсын нэр, нутаг дэвсгэрийг өөрчлөх талаарх бүх нийтийн санал хураалт»-тай

¹ Ли Цзу-шунь. Гунтоу вэй гогоуань, сяожэопянь гуанхуань (Бүх ард түмний санал хураалт сорилтыг давсангүй, түүний ялгарах сул талууд) <http://forums.chinatimes.com/report/2004president/plebiscitum/htm93032110.htm>

² Цзянь Цзянь-Чжан, Люй Шуан-хуй. Гунтоу фалиюань санду тунго («Бүх ард түмний санал хураалтын тухай хуулийн» Хууль тогтоох юань дахь гурав дахь хэлэлцүүлэг). <http://andywant.chinatimes.Com.tw/scripts/chinatimes/iscstext.exe>.

холбоотой, ард түмэнд эргэлзээ төрүүлсэн заалтуудыг няцаасан нь Тайванийн хоолойн хоёр талын хооронд цэрэг дайны түгшүүртэй байдлыг өдөөх магадлалыг арилгана³.

3/ Хууль тогтоох юаньд бүх нийтийн санал хураалт явуулах эрх олгох тухай заалтыг няцаасан байна. Хууль тогтоох байгууллага нь ямар ч асуудлын талаар ямар ч хэлбэрээр бүх нийтийн санал хураалт явуулж болохгүй гэдгийг бас тодорхой заасан байна. Үүнийг зөрчсөн тохиолдолд шүүхийн мөрдөн шалгалт явуулж, бүх нийтийн санал хураалт явуулахад гаргасан зардлыг хураан авч болох юм. Энэ бүхэн нь нийгэмд тайван бус байдал бүрэлдэх магадлалаас үр ашигтай сэрэмжлэхэд чиглэж байгаа юм.

4/ Дөрөв дэх атомын цахилгаан станц барих ажлыг зогсоохтой холбоотой нөхцөл байдал үүсэхээс сэрэмжлэхийн тулд⁴ нийгмийн тохижилтын төслүүд няцаагдсан тохиолдолд тэдгээрийн талаар ингэж тодорхойлсон: “санал хураалтын үр дүнг зарласан өдрөөс эхлэн барилгын ажил дуусч, ашиглалтад өгсөнөөс хойш 8 жилийн турш асуудлын дахин гаргаж ирж болохгүй”.

5/ «Батлан хамгаалахын бүх нийтийн санал хураалтын тухай хууль» гэгчийн 17-р зүйлд ингэж заасан байна: «Улс оронд гадны аюул нүүрлэсэн юм уу үндэсний бүрэн эрхээ алдах аюул үүссэн тохиолдолд Ерөнхийлөгч Хууль тогтоох юанийн Танхимын шийдвэрийн дагуу үндэсний аюулгүй байдлын асуудлуудыг бүх нийтийн санал хураалтад тавьж хэлэлцүүлнэ». Үүний утгыг Ардчилсан дэвшилтэт нам дэлхийн хамтын нийгэмлэгт анхандаа ингэж тайлбарлаж байсан юм: Ардчилсан дэвшилтэт нам бүх нийтийн санал хураалт явуулахыг одоо байгаа зүйлсийг өөрчлөх зорилготойгоор огт санаачлаагүй, энэ нь зүгээр л «батлан хамгаалахын тухай бүх нийтийн санал хураалт» болохоос «тусгаар тогтнолын талаарх бүх нийтийн санал хураалт» биш бөгөөд энэ нь эх газрын Хятадын зүгээс Тайваний хоолойн байдлыг өөрчлөх магадлалаас сэрэмжлэхэд чиглэж байгаа юм⁵.

4. Ерөнхийлөгч Чэнь Шуйбянь бүх нийтийн санал хураалт явуулахгүй идэвхтэй дэмждэг. Гүйцэтгэх юань «Бүх нийтийн санал хураалтын тухай хуульд оруулах

³ «Гуншан шибао»-гийн редакцийн булан. Тайду гунтоу шоуцзо (Тайваний тусгаар тогтнолын талаарх бүх ард түмний санал хураалт бүтэлгүйтсэн нь) 2003.11.28/. <http://andywant.chinatimes.Com.tw/scripts/chinatimes/iscstext.exe>.

⁴ Тайваний эдийн засгийн сайд Линь Синь-и-гийн мэдээлснээр тус арлын засгийн газар дөрөв дэх атомын цахилгаан станц барихад 90 тэрбум шинэ тайвань доллар зарцуулсан аж. Урсгал засвар хийх болон цөмийн түлш худалдан авахад бас 130-200 тэрбум тайвань доллар шаардагдах юм. 40 жил ажилласны дараа 330 тэрбум тайвань доллар зарцуулах шаардлагатай болно. Нийт зардал нь 550 тэрбум тайвань доллар болно. Хэрэв дөрөв дэх атомын цахилгаан станцыг барих ажлыг зогсоовол тогоонуунууд зэрэг тоног төхөөрөмжийг ашиглахад гарах зардал 30 тэрбум орчим тайвань доллар байх юм. 2 сая 700 мянга орчим Мвт-ын хэрэглээний хүчин чадалтай цахилгаан станцууд барихад зөвхөн 50 тэрбум тайвань доллар шаардагдана. Дээр дурдсан бүхэн нь Тайваньд дөрөв дэх атомын цахилгаан станц барих санааг ингэж их эсэргүүцэж байгаагийн шалтгаан болсон юм.

⁵ Чэнь Цзя-хун. Гунтоу вэньти чу цзай лифа (Хууль тогтоомж дахь бүх нийтийн санал хураалтын тухай асуудлын мөн чанар)

өөрчлөлтүүдийг» Парламентаар хэлэлцүүлэхээр оруулсан түүнийг нь Парламент дахь сөрөг хүчний төлөөлөл няцаасан юм. Үүний дараагаар ерөнхийлөгч Чэнь Шуйбянь бүх нийтийн санал хураалтын тухай хуулийн 17-р зүйлд үндэслэн «батлан хамгаалахын тухай бүх нийтийн санал хураалт» явуулах тухай зарласан нь дотоодод ч, гадаадад ч ихээхэн анхаарал татсан юм.

Тайваньд бүх ард түмний санал хураалт явуулсан нь

1. Бүх нийтийн санал хураалт явуулах сэдэв.

Тайваний нийгмийн янз бүрийн давхаргад бүх нийтийн санал хураалт явуулах асуудалд ихээхэн дургүй байсан болон эх газрын Хятад хийгээд дэлхийн хамтын нийгэмлэгийн зүгээс шүүмжилж, тэгээд ч АНУ хүчтэй шахалт үзүүлж байсан учир ерөнхийлөгч Чэнь Шуйбянь бүх нийтийн санал хураалтын сэдэв болон агуулгыг хэд хэдэн удаа өөрчлөхөд хүрч байсан аж. Анхандаа «өөрийг хамгаалах асуудлаарх бүх нийтийн санал хураалтын» тухай яригдаж байсныг «батлан хамгаалахын тухай бүх нийтийн санал хураалт» болгон сольсон бөгөөд эцсийн бүлэгт «энх тайвны тухай бүх нийтийн санал хураалт» гарч ирсэн. Эхний бүх нийтийн санал хураалтын сэдэв нь: «Засгийн газар Тайваний өөрийгөө хамгаалах чадварыг бэхжүүлэхийн тулд пуужингийн эсрэг зэвсэглэлийг нэмж худалдан авахыг та сайшааж байна уу» гэж байсан бол бүх нийтийн санал хураалтын хоёр дахь шатанд «Засгийн газар Тайваний хойгийн хоёр эрэг дээр энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилгоор Хятадын Коммунист намтай хэлэлцээ хийж эхэлсэнтэй та санал нэгтэй байна уу»⁶ гэсэн сэдэв дэвшүүлж байв.

2. Бүх нийтийн санал хураалт явуулахыг ард түмэн эсэргүүцэж байгаагийн шалтгаанууд:

1/ Хоёр сэдэв нь хоёулаа бүх нийтийн санал хураалтын тухай хуулийн 17-р зүйлд тодорхойлсон бүх нийтийн санал хураалтын эрх мэдлээс илэрхий давсан байв – «Улс оронд нүүрлэсэн шууд аюул занал, төрийн бүтцийг өөрчлөх магадлал». Хэрэв бүх нийтийн санал хураалтыг ингэж чөлөөтэй тайлбарлах юм бол хожим нь аль нэг төрийн тэргүүн бүх

⁶ 6/Чжунго шибаогийн редакцийн булан. Гэньти цзай ченно, бу цзай гунтоу (Асуудлын гол нь бүх нийтийн санал хураалтын тухай биш дэмжиж байгаа эсэхэд оршино) 2004.04.07. <http://andywant.chinatimes.com.tw/scripts/chinatimes/iscstext.exe/>

нийтийн санал хураалт явуулах уу, үгүй юу гэдгийг шийдэх эрхтэй болох ба энэ нь «нэр төр хөөцөлдсөн» байдалд хялбархан хүргэж, хууль эрх зүүн маргаанууд үүсгэж болох юм⁷.

2/ «Пуужингийн эсрэг зэвсэглэл худалдан авах болон Тайваний хоолойн хоёр талын хооронд хэлэлцээ хийх» гэсэн бүх нийтийн санал хураалтын сэдэв нь анхандаа засгийн газрын эрх мэдлийн хүрээнд хамарч байсан ба ард түмний дунд сөргөлдөөн үүсгэж, бүх нийтийн санал хураалт явуулахад ард түмний хөрөнгөөс 100 сая юань үрэх шаардлага огт байгаагүй юм.

3/ Дэг журмын үүднээс бүх нийтийн санал хураалт явуулах нь утгагүй байсан бөгөөд бүх нийтийн санал хураалтын агуулгын мөн чанарын хувьд бол түүнийг явуулах шаардлагагүй байсан юм. Бүх нийтийн санал хураалт явуулах зорилго нь сонгуульд ялах гэсэн Ардчилсан дэвшилтэт намын эрмэлзэл бөгөөд ингэхдээ агуулга чухал биш байгаа юм гэж ард түмэн сэжиглэж байна. Бүх ард түмний санал хураалт явуулахын төлөө байгаа Ардчилсан дэвшилтэт намын тактик нь бүх нийтийн санал хураалтыг сонгуульд ялах тактикийн зэвсэг болгон хувиргахад оршиж байна. «Энх тайвны тухай бүх нийтийн санал хураалт» гэдэг нь анхандаа «пуужингийн эсрэг» гэсэн агуулгыг «пуужин худалдан авах болон Тайваний хоолойн хоёр талын хооронд хэлэлцээ хийх» гэж хувиргахад оршиж байв. Бүх нийтийн санал хураалт явуулах шаардлага байхгүй гэж үзэж байна⁸.

4/ Бүх нийтийн санал хураалт явуулахад ард түмний санаа бодол ба шудрага ёс хангалтгүй тусгагдсан. Ардчилсан дэвшилтэт намаас бүх нийтийн санал хураалт явуулахад ард түмний санаачлага байхгүй байгаа бөгөөд бүх ард түмний санал хураалт явуулахад санал болгосон сэдвийг эхнээсээ нийт ард түмнээр шалгаагүй байсан болохоор үүнийг ард түмэн Чэнь Шуйбянь болон түүний тойрон хүрээлэгчдийн шаардаж буй зүйл л гэж ард түмэн үзэж байна⁹.

3. Бүх нийтийн санал хураалт явуулахыг Ардчилсан дэвшилтэт нам дэмжиж байгаагийн шалтгаанууд:

1/ Ерөнхийлөгч Чэнь Шуйбянь «ардчиллын үйл явц гүнзгийрч, ард түмэн эзэн болж хувирч байгаа» тухай мэдэгдэхдээ үүнд л ард түмний хүсэл зориг илэрч байгаа гэж нотолж байв.

⁷ Ло Жу-лань. Гунтоу чжань Ланьцзюнь Сань цзедуань чаньдоу («Хөхийн бүлэг» бүх нийтийн санал хураалтын талаар тулалдаанд татагдан гурван үе шат) 2004.04.07.
<http://andywant.chinatimes.com.tw/scripts/chinatimes/iscstext.exe>.

⁸ Ли Юй. Гунтоу – хами ваньгао (Бүх нийтийн санал хураалт нь – хамигаар хийсэн аяга) 2004.04.13.
<http://andywant.chinatimes.com.tw/scripts/chinatimes/iscstext.exe>.

⁹ Цзан Чоу-лин. Вэ цзянь во сы, миньчжу цзуй дади вэйсе (Миний үзэл бодол миний санал бодол нь ардчилалд хамгийн их аюултай) 2004.04.13.
<http://andywant.chinatimes.com.tw/scripts/chinatimes/iscstext.exe>.

2/ Бүх нийтийн санал хураалт явуулах нь санаа, санал бодол, хуулиудыг нэгтгэх сайхан тохиолдол болсон байна. Хэр эх газрын Хятад Тайваний эсрэг цэргийн хүч хэрэглэсэн бол бүх нийтийн санал хураалт явуулах нь хожимдсон арга хэмжээ болох байсан юм.

3/ Батлан хамгаалах асуудлаар бүх нийтийн санал хураалт явуулах нь гадны аюул заналхийллийн эсрэг чиглэсэн ард түмний ардчилсан эрмэлзлийн илрэл болсон байна.

4/ Бүх нийтийн санал хураалтыг бүх нийтийн сонгуультай нэг өдөр явуулах боломжтой бөгөөд ингэхдээ санал өгөх эрх чөлөөг хязгаарлахгүй юм.

Тайваньд бүх ард түмний санал хураалт явуулахад олон улсын хамтын нийгэмлэг болон эх газрын Хятадын зүгээс үзүүлсэн хандлага:

1/ АНУ-ын байр суурь. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш БНХАУ-ын дарга Ху Жинтаотой уулзахдаа Тайваний удирдагчид бүх нийтийн санал хураалт явуулах бодолтой байгаа нь Америк, Тайваний харилцаанд түгшүүртэй байдал бий болгож байна гэж тэмдэглэжээ. Тайвань бүх нийтийн санал хураалт явуулах нь Тайваний хойгийн нөхцөл байдлыг өөрчилж чадахгүй болов уу гэж АНУ-ын төрийн бичгийн даргын орлогч Армитаж хэлсэн байна.

2/ Францын байр суурь. «Франц улс Тайваний тусгаар тогтнолын эсрэг байгаа. Тайвань бүх нийтийн санал хураалт явуулах нь бүс нутгийн тогтвортой байдалд нөлөөлөх «ноцтой алдаатай зүйл юм» гэж Францын ерөнхийлөгч Жак Ширак 2004 оны нэгдүгээр сарын 24-нд БНХАУ-ын дарга Ху Жинтао Парист айлчлах үеэр мэдэгдсэн байна¹⁰. Нөхцөл байдлыг өөрчлөхийг, түүний дотор бүх нийтийн санал хураалт явуулахыг, Тайваний хойгийн байдлыг хурцатгахыг, Тайваньд тусгаар тогтнол олгоход чиглэгдсэн ямар нэгэн арга хэмжээг дангаар авч хэрэгжүүлэхийг Францын засгийн газар эсэргүүцэж байна¹¹.

3/ Япон болон бусад орны байр суурь. Японы гадаад хэргийн яам болон бусад улс орнууд Тайванийн хойгт өөрчлөлт гарахыг турхирч болзошгүй «бүх нийтийн санал хураалт» явуулах талаар сэтгэл зовниж байгаагаа илэрхийлжээ¹².

4/ Эх газрын Хятадын байр суурь. Хятадын коммунист нам Тайваньд бүх нийтийн санал хураалт явуулахыг эсэргүүцэж байгаа бөгөөд Тайвань нэг мэдэхэд бүх нийтийн санал

¹⁰ Го Шу-минь, Ху Ли-цзун. Сихакэ: Тайвань гунтоу. Яньчжун цоу (Ширак: Тайваний бүх нийтийн санал асуулга – ноцтой алдаа) «Чжунго шибао» 2004.01.27

¹¹ Цай Шоу-цин. Сихакэ: Тайвань гунтоу бу фүцзэжэнь эрцзе вэйсянь (Тайваньд бүх нийтийн санал хураалт явуулах нь хариуцлагагүй, тэр бүү хэл аюултай) «Чжунго шибао» 2004.01.28

¹² «Чжунго шибао»-гийн редакцийн булан. Сюаньцзю гунтоу (Бүх нийтийн санал хураалт явуулах нь) 2004.01.17

хураалтаар «Тайваний тусгаар тогтнолын» тухай асуудал хэлэлцүүлнэ гэж сэтгэл зовниж байна. Учир нь хэрэв өнөөдөр бүх нийтийн санал хураалт явуулаагүй бол дараа нэг явуулж болох бөгөөд энэ нь «зүссэн хиамны үр нөлөө» гэдэгтэй утга нэг байх юм.

Бүх нийтийн санал хураалтын үр дүн

1/ Тайваний хойгийн хоёр талын аль алинд няцаасан. Бүх нийтийн санал хураалтын тухай хуулийн дагуу санал хураалтын үр дүн нь санал хураалтад оролцогсдын саналын хуудасны тал хувь нь байх ёстой бөгөөд дэмжигчдийн тоо эсэргүүцэгчдийн тоог давсан тохиолдолд л бүх нийтийн санал хураалтыг болсон гэж үзнэ. Ийнхүү эхний бүх нийтийн санал хураалтад санал өгөх эрхтэй хүмүүсийн тоо 16.497.746 байсан ба зөвхөн 8.248.873 саналын хуудас байсан тохиолдолд бүх нийтийн санал хураалтыг болсон гэж тооцож болох байв. «Үндэсний батлан хамгаалахыг бэхжүүлэх тухай» нэгдүгээр асуудлаар саналаа өгсөн хүмүүс 45,17% болсон байна. «Эрх тэгш яриа хэлэлцээний тухай» хоёр дахь асуудлаар саналаа өгсөн хүмүүс 45,12% болсон байна. Өөрөөр хэлбэл аль аль тохиолдолд тал хувь байх босгыг давж чадаагүй няцаагдсан аж.

2/ Санал тоолсон үр дүн¹³

-1- «Үндэсний батлан хамгаалахыг бэхжүүлэх тухай»: Саналаа өгсөн хүний нийт тоо 7.452.340, дэмжсэн хүний тоо 6.319.663 буюу 92,05%, эсэргүүцсэн хүний тоо 581.413 буюу 8,2%. Хүчингүй болсон саналын хуудас 359.711 байв. Дэмжсэн хүмүүсийн тоо эсэргүүцсэн хүмүүсийн тооноос давсан хэдий ч саналаа өгсөн хүмүүсийн тоо тал хувиас давж чадаагүй байна. Санал хураалтын үр дүнгээр төслийг няцаасан байна.

-2- «Эрх тэгш яриа хэлэлцээний тухай»: Тооллогын дүнгээр саналаа өгсөн хүний нийт тоо 7.444.148, дэмжсэн хүний тоо 6.319.663 буюу 92,05%, эсэргүүцсэн хүний тоо 545.911 буюу 7,95%. Хүчингүй болсон саналын хуудас 578.574 байв. Дэмжсэн хүмүүсийн тоо эсэргүүцсэн хүмүүсийн тооноос давсан хэдий ч саналаа өгсөн хүмүүсийн тоо тал хувиас давж чадаагүй байна. Санал хураалтын үр дүнгээр төслийг няцаасан байна.

3/ Явуулсан судалгааны шинжилгээ

Бүх нийтийн санал хураалт явуулахыг эсэргүүцсэн Лянь Чжань, Сун Чуюй нарыг дэмжсэн «хөхийн» бүлгийн талыг баримтлагчдын 8/10 нь эсэргүүцсэнийг «Ляньхэбао»-гийн явуулсан санал тооллогын шинжилгээ харуулав. Бүх нийтийн санал хураалтыг бас

¹³ Тан Ши. Шоуцы цюаньгосин гунтоу вей гогуань (Анхны бүх нийтийн санал хураалт сорилтыг давсангүй) «Тайвань жибао» 2004.03.21 1-р хуудас

дунд болон дээд боловсролын ажилтнууд дэмжээгүй нь бүх нийтийн санал хураалт нурах үндсэн шалтгаан болжээ¹⁴.

-1- «Хөхийн» болон «ногооны» эвслүүдийн төлөө өгсөн саналын тооцооны шинжилгээ. 90% нь Чэнь Шуйбянь – Сю-лянь нарыг дэмжин бүх нийтийн санал хураалт явуулахын төлөө саналаа өгсөн бол зөвхөн 7,1% нь эсэргүүцжээ. 82,8% нь Лянь Чжань – Сун Чуюй нарыг дэмжин бүх нийтийн санал хураалт явуулахыг эсэргүүцсэн бол Лянь Чжань – Сун Чуюй нарын эвслийг дэмжээгүй нь 20%-иас давахгүй байжээ.

-2- Намын бүрэлдэхүүнээр хийсэн шинжилгээ. Ардчилсан дэвшилтэт намын гишүүдийн 92,7% нь бүх нийтийн санал хураалт явуулахыг дэмжсэн бол зөвхөн 7,1% нь эсэргүүцсэн байна. Гоминьдан болон Анхны ардын намын чиг шугамыг дэмжигчдийн тоо 80%-иас давсан боловч Гоминьданы намын гишүүдийн 18,3%, Анхны ардын намын гишүүдийн 5,4% нь бүх нийтийн санал хураалт явуулахыг дэмжсэн байна. Бүх нийтийн санал хураалт явуулахыг дэмжсэн нам бусчуудын тоо 50,7% байсан бол эсэргүүцэгчдийн тоо 45,4% болжээ.

-3- Санал хураалтад оролцсон хүн амын шинжилгээ. Бүх нийтийн санал хураалт явуулах саналыг баримтлагчид залуучууд болон хижээл насныхныг, түүнчлэн дээд, дунд боловсрол эзэмшсэн хүмүүсийг өөрийн талд татаж чадаагүй байна. Залуучууд болон 30-49 настай дунд насныхан бүх нийтийн санал хураалт явуулахыг эсэргүүцсэн ба тэдний тоо 50% болжээ. Тэдгээрийн тоо нь бүх нийтийн санал хураалт явуулахыг дэмжигчдээс 7-9%-иар их байгаа юм. 60-аас дээш насны хүмүүс бүх нийтийн санал хураалт явуулахыг дэмжсэн /55,5%/ бөгөөд тэдний 41,1% нь эсэргүүцжээ. 30-аас доош насны болон 50-59 насны сонгогчдын бүх нийтийн санал хураалт явуулахыг дэмжсэн болон эсэргүүцсэн хүмүүсийн тооны зөрүү 3% давжээ.

-4- Боловсролын түвшингээр. Боловсрол өндөр болох тусам бүх нийтийн санал хураалт явуулахыг эсэргүүцэгчдийн эзлэх хувь нэмэгдэж байна. Дунд сургуулиас дээш боловсрол эзэмшсэн албан хаагчдын 50% нь бүх нийтийн санал хураалт явуулахыг эсэргүүцсэн ба их сургууль болон түүнээс дээш боловсрол эзэмшсэн хүмүүсийн дунд санал хураалтыг эсэргүүцэгчдийн эзлэх хамгийн өндөр /58,4%/ байсан байна. Бага боловсрол болон улсын сургуулийн дунд боловсрол эзэмшсэн хүмүүсийн тус бүр 60,1% болон 52,8% нь бүх нийтийн санал хураалт явуулахыг дэмжсэн байна.

¹⁴ Ю Ци-минь. Фаньянь 8 чен цзюлин, фанью 9 чен литин (8/10 нь эсэргүүцэж, 9/10 нь дэмжжээ) «Ляньхэ ваньбао» 2004.03.21

-5- Бүс нутгаар хийсэн шинжилгээ. Арлын өмнөд хэсгийн хошууд болон хотуудын оршин суугчдын дотор Ардчилсан дэвшилтэт намын талыг баримтлагчид 50%-иас давж, бүх нийтийн санал хураалт явуулах санааг дэмжсэн байна. Арлын умард хэсэг болон арлуудын оршин суугчдын дунд бүх нийтийн санал хураалт явуулахыг дэмжигчдийн тоо 50%-д хүрээгүй ажээ.

Ерөнхийлөгчийн сонгууль хүчин төгөлдөр болж бүх нийтийн санал хураалтаас үүдэлтэй маргаан шийдвэрлэгдээгүй үлдсэний гол шалтгаанууд

-1- Хуулийн санаа болон үг үсэг нийцсэн байдал. Тайваньд бүрэлдсэн улс төрийн өнөөгийн нөхцөл байдал одоогоор Бүх нийтийн санал хураалтын тухай хууль буюу «Улс оронд шууд аюул нүүрлэж байгаа юм уу төрийн эргэлт хийх магадлал» гэсэн түүний 17-р заалтад нийцэхгүй байна гэж ард түмэн үзэх хандлагатай байна. Өөрөөр хэлбэл батлан хамгаалахын тухай бүх нийтийн санал хураалт явуулах нөхцөл одоогоор бүрэлдээгүй байна гэсэн юм. Ардчилсан дэвшилтэт намын хүч тавин санаачилж буй бүх нийтийн санал хууралтын зорилго нь аль болох олон санал олж авахад оршиж байгаа юм¹⁵. Бүх нийтийн санал хураалтыг гуравдугаар сарын 20-нд ерөнхийлөгчийн сонгуультай нэг өдөр явуулах нь Чэнь Шуйбянийн улс төрийн үзэл бодолтой нийцэж байгаа бөгөөд Ардчилсан дэвшилтэт намд ашигтай юм¹⁶.

-2- Ард түмний санаа бодлыг харгалзаагүй дутагдал болон цагийг нь олоогүй байдал. Батлан хамгаалахын тухай бүх нийтийн санал хураалт нь улс оронд цэргийн ноцтой аюул нүүрлэсэн цөвүүн цагт хэрэглэх эцсийн хэрэгсэл болохоос биш ард түмнийг санал хураалтад татан оролцуулах арга биш юм. Энэхүү бүх нийтийн санал хураалтыг явуулах цаг нь болоогүй байв. Гэсэн хэдий ч эрх баригч нам уг санал хураалт нь ийм байдлаар Тайванийн оршин суугчдын бүх нийтийн санаа бодлыг авч байгаа анхны бүх нийтийн санал хураалт юм гэж бүх ард түмэнд тайлбарласан 9 сая саналын хуудас бэлтгэхийг гүйцэтгэх байгууллагууддаа үүрэг болгосон байна. Үнэн хэрэгтээ бүх нийтийн санал хураалтаар хэлэлцэх сэдвийг тодорхойлохдоо ард түмний санаа бодлыг огт ашиглаагүй бөгөөд шийдвэр гаргах үйл явц нь дээрээс доошоо чиглэж байсан ба ард түмэн ерөнхийлөгчийн санааг илэрхийлэх туслах механизмын үүрэг гүйцэтгэхэд хүрсэн болохоор санаа бодлоо илэрхийлэх нэгдлийн тухай ярих ч юм байхгүй байв. Бүх нийтийн санал

¹⁵ “Чжунши ваньбао” –гийн редакцийн нийтлэл. “Сюаньцзю гунтоу” (“Бүх ард түмний санал асуулга явуулах”) 2004.01.17

¹⁶ Ло Жү-лань. Гунтоу чжань, ланьцзюнь Сань цзедуань чаньдоу (Бүх ард түмний санал асуулгыг тойрсон тэмцэл. “Цэнхэрийн” лагерийг татан оролцуулах 3 дахь үе)

хураалт нь мөн чанараараа ард түмний санаа бодлыг харгалзаагүй болон цаг үеэ олоогүй байдалтай байв.

-3- Эрх тэгш байдал, дагах горим журам байхгүй байва. Ардчилсан дэвшилтэт нам “Тайван бүх нийтийн санал асуулга”, “Ерөнхийлөгчийн сонгуулийг” нэгэн зэрэг явуулахдаа эрх тэгш байдлын тухай тунхагласан юм. Гүйцэтгэх юань өөрийн гүйцэтгэх үүргийнхээ дагуу сонгууль хийлгэх болон хэдэн арван сая шинэ тайвань доллар хэмнэнэ гэдэг нэрийдлээр Сонгуулийн хороог бүх нийтийн санал асуулга, сонгуулийн асуудлаар шийдвэр гаргахад хүргэв. Үүнийг Сонгуулийн хорооны гишүүд эсэргүүцэж, халаа солио¹⁷ хийхэд хүргэн, ард түмэн сонгуулийн явцыг таагүй хүлээн авч, сонгуулийн явцад “эрх тэгш байдал, дагах гор байхгүй” байгаа явдлыг онцлон харуулав¹⁸.

-4- бүх нийтийн санал асуулга нь сонгууль явуулахад тусалсан зэвсэг болов. Ардчилсан дэвшилтэт нам “Тайвань 100 бүх нийтийн санал асуулгыг” сонгохыг сонгогчдод илэрхий уриалж, тэгснээрээ бүх нийтийн санал асуулга нь ерөнхийлөгчийн сонгууль явуулах зэвсэг боллоо гэдгийг тодорхой харуулсан юм. Чэнь Шуйбянийг анхны ерөнхийлөгчөөр сонгох ёстой байв, бүх нийтийн санал асуулгын хоёр хуудсыг хавсаргасан байлаа. Тэд “100”-г дэмжиж “0” гэсэн тэмдэг тавих ёстой байв. Өөрөөр хэлбэл ард түмний санал асуулгыг тэд эх баригч намын зэвсэг мэт ашигласан¹⁹.

Сонгууль, бүх нийтийн санал асуулга юу харуулсан бэ?

1. Ардчиллын үйл явц гүнзгийрч байна гэсэн байрь суурь батжин тогтов. Тайвань бол субъект гэсэн сэдэв батлагдав. Тайваний түүхэнд анх удаа явуулсан бүх нийтийн санал асуулгын дүнгээр тэр дэмжлэг авгаагүй ч арал АНУ-аас зэвсэг худалдан авсаар байна. Тайваний хоолойн хоёр талын харилцааг энх тайван аргаар хэрхэн шийдвэрлэх нь засгийн газрын улс төрийн зорилго болж байна. Тайвань бол субъект гэдэг сэдэв улам бүр бодит байдал болж байна²⁰.

Ардчиллын үйл явцыг гүнзгийрүүлэгч бүх нийтийн санал асуулгаар сонгуулийн явцад өрсөлдөгч нарт сайн, муу үнэлгээ өгөөд зогсохгүй бас төрөөс явуулж байгаа бодлогод хувьдаа хэрхэн хандаж байгаагаа шууд илэрхийлж болохыг Тайваний ард түмэн ухамсарласан билээ. Ингэхэд ардчиллын үндсүүд улам бүр тогтвортой, тал бүрийн болж,

¹⁷ Жу Юнь-хань. Тайвань дахь ардчиллын сонгуулийн тавцан

¹⁸ Зан Чоу-линь Миний үзэл бодол, миний санал, ардчилалд учрах ялхгүй аюул

¹⁹ “Гуншан шибao”-ийн редакцийн багна дээр. Гунтоу бьяньчжэ сюань гунцзю (Ард түмний санал асуулга нь сонгууль явуулах зэвсэг болсон)// “Гуншан шибao” 2004.03.01

²⁰ Сю Сяозы. Бүх нийтийн санал асуулгын уршиг гэвэл ардчилал живж байгаа явдал юм

Тайвань хэмээх субъектыг баталснаар Тайваний ард түмэн өөрийн ирээдүйгээ тодорхойлох бололцоотой болно²¹.

2. Популизмыг эсэргүүцэв. Ардчилсан дэвшилтэт нам ард түмэн саналын хуудсандаа “100” гэсэн билэгдлийг сонгохыг шаардахдаа “бүх нийтийн санал асуулга”, “ардчиллын эсрэг, ХКН-ын эсрэг, Тайваньд хайртай” гэх мэтийн ойлголтуудыг хамтатган хольж хутгасан юм. Энэ нь ард түмний санал асуулга явуулах асуудлыг зөвшөөрөх гэсэн эрмэлзлийг ашиглан эрх баригч нам популизмын үзэл санааг татах гэсэн эрмэлзэлтэй төсөөтэй байна. Бүх нийтийн санал асуулга явуулах үзэл санаа няцаагдсан болохоор энэ нь ард түмний тэн хагасаас илүү нь популизмын үзэл санааг эсэргүүцэж байгаагийн илрэл болжээ.

3. Бүрэн эрхт байдлын тухай асуудлын үндэс суурийг үгүй хийх бололцоо байхгүй. АНУ, БНХАУ хоёр Тайваний хөгжилд үзүүлэх нөлөөгөө нэмэгдүүлж байна. Одоо Чэнь Шуйбянь түрүүнд сэргэлдэж байснаа одоо Америктай хэд хэдэн сэдвийг хэлэлцдэг болтол байр сууриа өөрчилж байгаа бөгөөд хориглолтын чанартай бүх нийтийн санал асуулгыг энх тайван санал асуулгаар солив. Ийнхүү тэр Тайваньд ардчиллыг гүнзгийрүүлэх хэмжээг бүрэн эрхт байдалтай холбогдсон маргаанаар хязгаарлах боломжгүйг ард түмэндээ тодорхой харуулав. Тэр маргаан нь Америк, БНХАУ-ын тавьж байсан болзол билээ. Тайваний үйл ажиллагаатай холбогдуулан АНУ Тайваний хоолойн хоёр талын харилцааг зохицуулах хүрээгээ байнга өөрчилж байдаг нь өөрчлөгдөн буй орчин үеийн нөхцөл байдалд Тайваний орон зайг хязгаарлаж байна.

Бүх нийтийн санал асуулгын дараах Тайваний хөгжлийн хэтийн төлөв

1. Санал асуулга нь эрх баригч нам болон гүйцэтгэх засаглалын байгууллагуудын хувьд практик зэвсэг болно. Энэ бол Тайваньд бүх нийтийн санал асуулга явуулж, хүн амыг улс төрийн асуудал хэлэлцэхэд идэвхтэй татан оролцуулсан анхны туршлага болсон боловч ирээдүйд янз бүрийн асуудлаар явуулах ард түмний санал асуулга тайваньчуудын өдөр тутмын амьдралын бодит байдал болж болох юм. Бүх нийтийн санал асуулга нь эрх баригч нам, гүйцэтгэх засаглалын байгууллагуудын хувьд практик зэвсэг болж хувирна.

²¹ Ян Юйцзэнь. Бянь гогоуань, бяньды гунтоу юйгобуляо гуань // “Ляньхэбар” 2004.03.21

Харин ард түмэн бүх нийтийн санал асуулга явуулах эрх л үлдээд түүнийг явуулсны ашгийг хүртэхгүй хэмээн болгоомжилж байна²².

2. Тайвань Америк, Хятадтай харилцан итгэлээ дахин сэргээх ёстой. Бүх нийтийн санал асуулгад зориулан дэвшүүлсэн сэдэв улс төрийн хүчтэй шуурга шууруулав. Тайвань, Америкийн итгэлтэй харилцааны систем хамгийн их хохирол амсаж, ерөнхийлөгчийн албан тушаалд байх хугацаагаа сунгуулж чадсан Чэнь Шуйбянь бүх талаар хожив²³. Тайван бүх нийтийн санал асуулга явуулсныг их газрын Хятад хагалан бутаргах ажиллагаа гэж нэрлэв. Гэхдээ санал асуулга Америкийн шахалтаар хязгаарлагдмал болж, сонгууль явуулах хэрэгцээ болон хувирсан билээ. Тайвань орчин үеийн байдлыг өөрчлөхгүй, тэгэхийг ч зориглохгүй, цаашдаа бүх нийтийн санал асуулга бодитой утга учиргүй байх болно гэдэг баталгааг БНХАУ АНУ-аар дахин гаргуулж авлаа. Тэглээ ч гэсэн энэ нь БНХАУ, АНУ-ын зүгээс Тайваньд үл итгэх байдал төрүүлэв²⁴. Ийм учраас Ардчилсан дэвшилтэт нам сонгуулийн дараа Тайвань, Америкийн харилцааны байдлыг засч залруулан, эх газрын Хятадтай хэлэлцээ хийх сувгийг сэргээх явдлыг өөрийн амин чухал зорилго хэмээн тодорхойлж байна.

3. Цаашдаа бүх нийтийн санал асуулга явуулахдаа түүний агуулгыг анхлан тодорхойлж байх ёстой. Ардчилсан дэвшилт намаас саяны бүх нийтийн санал асуулгыг дараа хэлбэрээр явуулав: эхлээд бүх нийтийн санал асуулга явуулах зайлшгүй шаардлагыг тодорхойлоод дараа нь түүний сэдвийг нэрлэв. Цаашдаа шинээр баталсан хууль ёсоор ерөнхийлөгч Чэнь Шуйбянь эхлээд цаг хугацааг тодорхойлж, дараа нь агуулгын талаар саналаа хэлэх ёстой.

Дүгнэлт

Тайваний хувьд олон улсын тавцанд ХКН-аас дээгүүр гарахын төлөө тэмцэл хийж болох талбар улам бүр багасаж байна. Эх газрын Хятадын эдийн засгийн хүчин чадал тасралтгүй өсч байгаа болохоор Тайваний худалдаа-эдийн засгийн нөлөө буурч байна, ХКН-аас олон улсын үйл явдалд үзүүлэх нөлөө өдрөөс өдөрт нэмэгдэж, Тайваний асуудлаар дэлхийн хэмжээний гүрнүүдэд улам хүчтэй нөлөөлж байна. Эх газрын Хятадын цэргийн хүчин чадал улам бүр орчин үеийн болж байхад Тайваний санхүүгийн

²² Минь Вэйминь. Тайваний анхны бүх нийтийн санал асуулга бүтээгүй ч хэлэлцсэн асуудлууд улам тодорхой болсон

²³ Ван Мин-и. Во цзянь во сы. Цзяньсо вэй цзянь ды Тай-Мэй-Жун гуаньси. Жунго-шибао"-гийн редакцийн нийтлэл. 2004.02.11

²⁴ Жан Яжун. Бүх нийтийн санал асуулга Тайваний хоолойн байдалд нөлөөлөв

хангамж улам бүр ядуурч байна. Тайваний хоолой дахь ажил байдал АНУ-ын олгож буй аюулгүй байдлын баталгаанаас улам их хамааралтай болж байна. Ийнхүү Тайвань дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэг хүлээж, өөрийн ардчилсан ололтод илүү их тулгуурлан, ардчилсан зарчмуудаа, олон улсын тавцанд язгуур эрх ашгаа хамгаалах ёстой. Энэ нь ялангуяа Тайваний олон улсын байдлын асуудал, Тайваний хоолойн хоёр талын харилцааны асуудлаарх бүх ард түмний санал асуулгад хамаарна. Тийм санал асуулга Бээжингийн явуулж байгаа бодлого, цэргийн нөлөөллийг сөрөн эсэргүүцэх сүүлчийн арга болж байна. Ийм учраас Тайваний ерөнхийлөгч бүх ард түмний хориглолтын чанартай санал асуулга явуулахдаа сэдэв сонгох, өдөр тогтоох, санал асуулга явуулах хэлбэрийг олохдоо туйлын хянуур байх ёстой. Тайваний явуулж буй “улс төрийн талаар үндэслэлтэй хориглолтын чиг шугамын” талаар бүх ардчилсан гүрний дэмжлэгийг заавал хүлээх ёстой. Зөвхөн ингэж байж ард түмний итгэл хүлээж болно. Энэ сүүлчийн аргыг хэрэглэн хүрээлэн буй улсуудтайгаа²⁵ зөвлөлдвөл зохино, тэгснээрээ бүх нийтийн санал асуулга нь ХКН-тай харилцах харилцаанд Тайваний явуулсан нэг талын ажиллагаа биш гэдгийг харуулах болно. “Нэгдэл, тусгаар тогтнолын асуудлаарх бүх нийтийн санал асуулгын” агуулгыг нээвэл зохино, зарим шинж тэмдгээс үзвэл түүнийг олон улсын хамтын нийгэмлэг, ХКН хүлээн авч байх шиг байна. Бас бүх нийтийн санал асуулга Тайваний ардчилалын үйл явцыг гүнзгийрүүлэх үү, эсвэл нөхцөл байдлыг сэргөлдөөний аюултай босгон дээр аваачих уу гэдгийг харуулах хэрэгтэй. Энэ нь Тайваньд ч, дэлхийн стратегийн нөхцөл байдалд ч хамаатай. Энэ бүхэнд Тайвань бүх нийтийн санал асуулга явуулахдаа ард түмний сайн сайхан байдлын зарчмыг иш үндэс болгон туйлын болгоомжтой байх ёстой.

²⁵ Жу Юань-хань. И чан дасюань жан Тайвань ды миньжу нэйвай (Тайваний ардчилалын сонгуулийн давцан)// “Чжунго шибао”-ийн редакцийн нийтлэл” 2004.03.16